

“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8-р сарын 12 өдөр

Дугаар: 21/03/01

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 заалт, 2021 оны 8 сарын 12-ны өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн албан ёсны хаягийг Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Централ Тауэр, 5-р давхар, 511 тоот өрөө болгон өөрчилсүгэй.
2. Компанийн оноосон нэрийг хавсралтад баталгаажуулсан хуулийн этгээдийн бүртгэлийн газрын нэрийн баталгаажуулалтын хуудсанд заасны дагуу өөрчилсүгэй.
3. Компаний үйл ажиллагааны чиглэлд ойн хушны самрыг бэлтгэх, боловсруулах; самрын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Гадаад дотоод худалдаа эрхлэх үйлчилгээг нэмж улсын бүртгэлд бүртгүүлсүгэй.
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА *О.Очилов* Г.ГОМБО



“ЛЮКС ЗАНАДУ ГРУПП” ХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 8-р сарын 12 өдөр

Дугаар: 21/03/02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2021 оны 8-р сарын 12-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын 21/02/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

Ердийн гишүүн

1. А.Хадбаатар
 2. Б.Болорцэцэг
 3. Б.Сугарсүрэн
 4. Б.Насан-Эрдэнэ
 5. Б.Одмаа
 6. Э.Болор-Эрдэнэ
2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

Хараат бус гишүүн

1. С.Отгонбилэг
 2. Г.Мөнхбаяр
 3. О.Нандинчимэг
3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ГОМБО

